

**РЕМИКОН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020.04.29

№... XZX 20 - 1

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.11, Ремикон ХК-ийн 2020 оны 4-р сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр зэргийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн
ажиллагааны тайланг батлах тухай

1. Ремикон ХК-ийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн дугаар 20/1/1 тоот дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.ЭРДЭНЭБАЯР



**РЕМИКОН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020.04.29

№ ХХХ 20 - 2

Улаанбаатар хот

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Ремикон ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.7, Ремикон ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, 2020 оны 04-р сарын 29-ны өдрийн Ремикон ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүнээр томилох тухай

1. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүнээр Х.Ганхуяг, Б.Батсайхан, И.Масатэргүү, Ч.Мөнгөнсүх, Ц.Эрдэнэбаяр, Э.Мөнхсайхан, Г.Батхуяг нарыг, хараат бус гишүүнээр О.Батбаяр, Р.Ганхуяг, Д.Алтанхуяг, С.Баянмөнх нарыг 2020 оны 4-р сарын 29-ны өдрөөс 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох хүртэл хугацаагаар тус тус томилсугай.
2. Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зохих журмын дагуу цалин, хангамжийг бодож олгохыг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЭРДЭНЭБАЯР